



НИДЕРЛАНДЫН ХААНТ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг)¹

ХИЙМЭЛ ОЮУН (AI) АШИГЛАН ПОРНОГРАФ (DEEPFAKE PORNOGRAPHY) ВИДЕО БҮТЭЭЖ, КИБЕР ОРЧИНД ТҮГЭЭСНИЙГ ГЭМТ ХЭРЭГ ГЭЖ ҮЗЭВ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: ECLI:NL:RBAMS:2023:6923

Шүүхийн шийдвэрийн огноо: 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр

Шийдвэрийн төлөв байдал: Анхан шатны шүүхийн шийдвэр (хүчинтэй)

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч нь хиймэл оюунд суурилсан (AI) программ ашиглан хохирогч эмэгтэйн царайг порно жүжигчний нүцгэн бие дээр эвлүүлж, бодит мэт харагдах порнограф видео бүтээж, хохирогчийн зөвшөөрөлгүйгээр кибер орчинд түгээжээ. Шүүгдэгч нь порнограф видеонд хохирогч эмэгтэйг бусадтай бэлгийн харьцаанд орж буй мэтээр дүрсэлсэн гэх хэрэгт холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Нидерландын Хаант Улсын Эрүүгийн хууль (1881)²-ийн Нийтийн хэв журмын эсрэг гэмт хэрэг бүлэгт 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Уг нэмэлт, өөрчлөлтөөр Эрүүгийн хуулийн 139h дүгээр зүйлд “бэлгийн харьцааны шинжтэй дүрс” (гол.afbeelding van seksuele aard) гэх ухагдахууныг шинээр нэмж хуульчилсан байна. Тодруулбал, бэлгийн харьцааны шинжтэй дүрс гэдэгт бэлгийн харьцааны шинжтэй үйлдлүүдийг илэрхийлэх зураг, видео бичлэг, дүрсийг хамруулжээ. Ингэснээр зөвшөөрөлгүйгээр бэлгийн харьцааны шинжтэй дүрсийг бүтээсэн, олж авсан, хадгалсан, түгээсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин бий болсон.

Хиймэл оюунд суурилсан программ ашиглан бүтээсэн зохиомол порнограф видео нь “deepfake pornography” гэсэн ухагдахуунд хамаарна. Дээрх хэргийн хувьд прокуророос шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 139h дүгээр зүйлд³ заасан “Бэлгийн харьцааны шинжтэй дүрсийг бүтээсэн, түгээсэн” гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлджээ.

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

<https://uitspraken.rechtspraak.nl/details?id=ECLI:NL:RBAMS:2023:6923>, (Сүүлд үзсэн: 2026.02.02).

² Wetboek van Strafrecht, (1881), <https://wetten.overheid.nl/BWBR0001854/2023-01-01/>, (Сүүлд үзсэн: 2026.02.02).

³ Эрүүгийн хуулийн 139h дүгээр зүйл. “Гэмт этгээд хохирогчийн зөвшөөрөлгүйгээр түүний бэлгийн харьцааны шинжтэй дүрсийг бүтээсэн, олж авсан, хадгалсан, түгээсэн бол дөрөвдүгээр зэрэгтэй тэнцэх хэмжээний еврогоор торгох, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”



Анхан шатны шүүхийн шийдвэр

Шүүхээс зохиомол порнограф гэх нэр томъёог хуульд шууд тусгаагүй боловч хууль тогтоогч “бэлгийн харьцааны шинжтэй дүрс” гэх ухагдахуунаар ирээдүйд бий болох кибер орчинд үйлдэгдэх гэмт үйлдлүүдийг хамруулах зорилготой байсан. Тодруулбал, бэлгийн харьцааны шинжтэй үйлдлийг бодитоор хийсэн эсэхийг шалгуур болгохгүй, харин тухайн дүрсийг гуравдагч этгээд хэрхэн хүлээн авахыг шалгуур болгоно хэмээн дүгнэжээ.

Шүүх порнографийн тусгай мэдлэг эзэмшсэн мэргэжилтнээр шинжлүүлэхэд тухайн видео нь хуурамч бөгөөд жирийн хүн уг дүрсийг хуурамч эсэхийг ялгах боломжгүй гэжээ. Үүнээс үзэхэд, [зохиомол порнограф нь бодит биш боловч гуравдагч этгээдэд бодит мэт ойлгогдохуйц байвал түүнийг бэлгийн харьцааны шинжтэй дүрс гэж ойлгоно.](#)

Хиймэл оюунд суурилсан программ ашиглан порнограф видео бүтээж, кибер орчинд түгээсэн гэмт хэрэгт шүүгдэгч нь хохирогчоос зөвшөөрөл авсан эсэхийг гол шалгуур болгодог. Тодруулбал, [бэлгийн харьцаанд орж буй дүрс нь бодит эсэхээс үл хамааран тухайн хүний дүрсийг ашиглаж байгаа нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдаж буй илрэл тул заавал зөвшөөрөл авсан эсэхийг харгалзан үзнэ.](#) Гэтэл шүүгдэгчийн үйлдэл нь хохирогчийн зөвшөөрөлгүйгээр порнограф видео бүтээж, кибер орчинд түгээсэн идэвхтэй үйлдэл байх бөгөөд уг гэмт хэрэг нь үйлдэл хийснээр төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм. Мөн шүүгдэгч нь хохирогчийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдах зорилгоор дээрх гэмт хэргийг гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдсэн байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 139h дүгээр зүйлд заасан гэмт хэргээр хамгаалж буй эрх ашиг нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал байна. Нөгөөтээгүүр, [бэлгийн харьцааны шинжтэй дүрсийг кибер орчинд түгээх нь олон нийтийн итгэл, кибер орчны аюулгүй байдалд халдах шинжтэй байдаг учраас хууль тогтоогч дээрх гэмт хэргийг Нийтийн хэв журмын эсрэг гэмт хэрэг бүлэгт хуульчилжээ.](#)

Анхан шатны шүүхээс шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 139h дүгээр зүйлд зааснаар хохирогчийн зөвшөөрөлгүйгээр түүний бэлгийн харьцааны шинжтэй дүрсийг бүтээсэн, түгээсэн гэмт хэрэгт гэм буруутайд тооцож, 180 цаг нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулжээ. Хэдийгээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 139h дүгээр зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн бол дөрөвдүгээр зэрэгтэй тэнцэх хэмжээний еврогоор торгох, эсвэл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан боловч [уг зохицуулалт нь ялын дээд хязгаар бөгөөд шүүх гэмт хэргийн шинж, шүүгдэгчийн гэмт хэрэг анх удаа үйлдсэн байдлуудыг харгалзан хөнгөн ял оногдуулах бүрэн эрхтэй байна.](#) Дээрх нөхцөлүүдийг харгалзан шүүгдэгчид 180 цаг нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулжээ.